



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023. 01. 02 № ЗТ-1/01
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
тухай

“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000062



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он // дугаар
сарын...-ны өдөр

Дугаар ХЭГ/2855

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт/... хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН


000225015567

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлд:

“ҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



「БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД」

Б.МӨНХБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022.11.15 № 01/7817
танай 2022.11.10 -ны № 1/5207 -т
「 Зөвшөөрөл олгох тухай 」

Танаас ирүүлсэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичигтэй танилцлаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9762005725



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn


2022.11.16 № 1/5828
танай 2022.11.10 ны № 1/5208-Т

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Б.МӨНХБААТАР ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



151605584
A5 Файл.2022



**“ОРХОНЫ ХӨНДИЙД ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хот, тосгон нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгт харьяалагдана.” гэж заасан. Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрхийг Монгол Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа -2050” баримт бичгийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан зорилт 8.2.-ын I үе шатны 8.2.3-т “Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ” гэж, II үе шатны 8.2.3-т “Шинэ нийслэлд төрийн захиргааны болон зарим нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэх ажлуудыг эхлүүлсэн байна”, III үе шатны 8.2.2-т “Шинэ нийслэлийг ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын бүтээлч хот болгоно” гэж тусгасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хавсралт 3.7.5-д “Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна”, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 дүгээр хавсралт 3.6.6-д “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийх” зорилтуудыг тус тус дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаар 2015 онд "Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030"-ыг баталж, ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих буюу хот, суурин газруудыг нийт иргэдэд зориулж аюулгүй, даван туулах чадвар сайтай, тогтвортой болгох тухай 11 дүгээр зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэхүү агуулгад тусгагдсаны дагуу хотжилтыг тогтвортой хөгжлийн зорилтуудын харилцан уялдах боломж хэлбэрээр хангах, хөгжлийн багаж, хөдөлгөх хүч болгохын үүднээс 2016 онд "НҮБ-ХАБИТАТ III их хурал"-аас баталсан "Хотжилтын шинэ хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлэхэд гишүүн улс орнуудын Засгийн газрууд анхаарч хүчин чармайлт гарган ажиллаж байна.

1.2. Практик шаардлага

Өнөөдөр дэлхийн хот, суурин газрууд нийт хуурай газрын 2 хувийг эзэлдэг хэдий ч нийт хүн ам нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын тооцоолсноор 2050 онд 2 дахин өсч, хотжилтын түвшин 70 хувьд хүрсэнээр 21 дүгээр зууны өөрчлөлтийн нэг гол чиг хандлага болж байна.

Монголчууд бид уламжлалт нүүдэлчин ахуй, соёлтой ард түмэн учраас эх газрын эрс тэс уур амьсгалтай, уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагт хүн амыг нутагшуулж, суурин газрыг хөгжүүлж ирсэн түүх нь дэлхийн бусад орнуудаас өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг. Судлаачдын судалж илрүүлсэнээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Хүннү гүрний буюу МЭӨ III зууны үеэс XX зууны эхэн үе хүртэлх хугацаанд хамаарагдах 300 гаруй хот суурины дурсгалыг бүртгэн тэмдэглэсэн байна. XIII зууны Монголын Эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг байгуулсан үеэс тал нутагт суурин газрын соёл нэвтэрч эхэлсэн бөгөөд түүнээс хойш нийгмийн хөгжлийн үе шатуудад үндэсний уламжлал, баялаг, өв соёлдоо түшиглэн тухайн нөхцөл байдалтай уялдсан архитектур, хот байгуулалтыг хөгжүүлж ирсэн түүхтэй. XX зууны дунд үеэс Монгол Улсад аж үйлдвэрлэлийн шинэ салбаруудыг хөгжүүлсэнээр хүн ам суурин амьдрал, хотжилт руу хурдацтай шилжих үе эхэлж орчин үеийн хот, тосгоныг олноор байгуулсан.

Монгол Улсын 2021 оны хүн амын статистик мэдээллээс үзэхэд, хотжилтын түвшин нь хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хурдацтай нэмэгдэж 72 хувьд хүрээд байгаа нь дэлхийн дунджаас 16 хувиар өндөр байна. Өнөөгийн байдлаар Нийслэл Улаанбаатар хотод манай улсын хүн амын 50 орчим хувь нь төвлөрч, төрийн байгууллагууд 100 хувь, их, дээд сургуулиудын 90 хувь, худалдаа үйлчилгээний 86 хувь, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Нийслэлийн хүн амын энэхүү эрчимтэй өсөлтийг дагаад хүрээлэн буй орчны доройтол, дэд бүтцийн даац хэтрэх, бүс нутгийн тэнцвэрт бус хөгжил, хотын ажилгүйдэл, ядуурал ихсэн хүн амын хэт төвлөрөл нь хот болон хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдалд хүргэж нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бий болгосоор байна. Мөн Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо нь нэг төвтэй болж, зарим талаар нийгмийн эрчимтэй хөгжилд сөрөг нөлөөг үзүүлэх үндсэн шалтгааны нэг болж байна. Тиймээс хүн амыг нутаг дэвсгэртээ тэнцвэртэй нутагшуулан суурьшуулах, Нийслэл Улаанбаатар хотоос бусад хот сууринг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Дэлхийн улс орнуудын хэмжээнд сүүлийн жилүүдэд иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний

хүртээмжийг тэгшитгэх, хэт төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах зорилгоор хүн ам хэт төвлөрсөн томоохон нийслэл хотуудыг бүхэлд нь болон хэсэгчлэн нүүлгэх, төр, захиргааны байгууллагуудыг байршлыг шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, улсын нийслэл хотоо нүүлгэн шилжүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улс, Малайз Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бразил Улс зэрэг гадаад орнуудын туршлагаас үзэхэд хуучин нийслэл дэх хэт төвлөрөл тодорхой хэмжээнд буурсан, хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит үр нөлөөг үзүүлсэн жишээнүүд байна.

Барилга, хот байгуулалтын яамнаас Орхоны хөндий орчимд хот байгуулалтын судалгааг үе шаттай хийж ирсэн бөгөөд 2005 онд шинэ хотын байршлыг урьдчилсан байдлаар тогтоох судалгаа, 2006 онд нийслэлийн баримжаатай жишиг хотын экологи-хот байгуулалтын үнэлгээ, 2009 онд Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, 2012 онд “Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын ирээдүйн төлөв, архитектур хот төлөвлөлт” судалгааны ажил /БШУЯ/, 2022 онд Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэлийг тус тус боловсруулсан. Мөн Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /ЖАЙКА/-ын техник туслалцааны хүрээнд Барилга, хот байгуулалтын яам болон Үндэсний хөгжлийн газар /хуучнаар/-тай хамтран 2019-2021 онд хэрэгжүүлсэн “Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах төсөл”-ийн тайланд “Нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлтийг оновчтой болгох, шинэ нийслэл хотыг Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хот эсвэл улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт байрлуулах” саналыг дэвшүүлсэн байна.

“Шинэ Хархорум хот” байгуулахаар төлөвлөж буй газар нутаг нь Монгол Улсын төв хэсэгт Хангай Хэнтийн их уулархаг мужын Орхон-Сэлэнгийн сав газрын Хангайн нурууны зүүн урд хэсгээс босоо тэнхлэгийн дагуу урдаас хойш 110км орчим урт сунаж тогтсон Орхон гол дагуух уудам хөндий юм. Тамирын голын Орхон голтой нийлж байгаа хэсэгт баруунаасаа зүүн тийш сунасан Орхон Тамирын уудам бэлчир нутагтай, нуга, Хангайн нурууны захын бэсрэг уулсын хээрийн ландшафт бүхий байгалийн үзэсгэлэнт тогтоц бүхий нутаг дэвсгэр юм. Орхоны хөндийн нутаг дэвсгэр нь Хангайн нурууны зүүн талд далайн төвшнөөс дээш дунджаар 1350-2300 метрийн өндөрт Өвөрхангай аймгийн Хархорин, Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Хашаат, Хотонт сумдыг дамнан, Улаанбаатар хотоос 360 км, Монгол улсын нутаг дэвсгэрийн төв цэгээс 100 км, Орхоны хөндийгээр хэвтээ чиглэлийн авто замын сүлжээ /Мянганы зам/ дайран өнгөрдөг. Тус бүс нутаг нь Алтай, Хангайн нурууны завсарт оршдог бөгөөд үндэсний онцлог бүхий түүхэн болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвхи нөөцтэй бүс нутаг юм.

Түүхэн ач холбогдолын хувьд Орхон голын сав нутаг, Орхоны хөндийн газар нь нүүдлийн соёл иргэншлийн газарзүйн гол зангилаа нутаг төдийгүй байгаль дэлхийтэй энгийн арга хэлбэрээр зохицон амьдарч байгааг харуулсан нүүдлийн ахуйг өдгөө ч хадгалсаар байгаа газар нутгийн төлөөлөл юм. Үүний зэрэгцээ хүн төрөлхтний нэн эртний түүхийг гэрчлэх чулуун зэвсэгийн үеийн дурсгал газрууд

болон нүүдэлчдийн анхны төрт улс үүссэн, эртний нүүдэлчдийн төр улсууд үе залгамжлан оршин тогтнож өрнө, дорнын харилцааны түүхэн төв болж байсныг гэрчлэх археологи-архитектурын дурсгалуудыг өнөөг хүртэл хадгалж ирсэн газар нутаг юм. Мөн Их эзэн Чингис хааны үндэслэн байгуулсан Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хот, Монгол дахь бурхны шашины бэлэг тэмдэг болсон Эрдэнэзуу, Төвхөн, Шанхын хүрээ зэрэг олон хот суурин газруудыг байгуулж байсан түүхтэй өлгий нутаг юм.

Тус газар нутагт хуучин чулуун зэвсэгийн үеийн "Мойлтын ам" болон "Орхон-7" бууц зэрэг эртний хүмүүсийн оромж, суурин, дарханы газрын ул мөр, хүрэл, төмрийн түрүү үеийн Шунхлай уулын дөрвөлжин булш, "Тэмээн чулуу"-ны дөрвөлжин булш, буган чулуун хөшөөд, Төв Азид анхны Төрт улсыг байгуулсан Хүннүгийн Лүн (Луут) хот, Жоужань улсын Муму (Мөөм) хот энэ бүс нутгийн хүрээнд байсан нь Хохь Түрэгийн хаант улсын Билгэ хаан, Куль-Тегин жанжин тэргүүтэй хаад ихсийн тахилын онгон, Уйгурын нийслэл Ордубалык буюу Хар балгасын ор үлдэгдэл нь өдгөө хүртэл энэ газар нутагт оршсоор байна. БНХАУ-ын Сужуо хотод 2004 онд хуралдсан ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооны 28 дугаар чуулганаар Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн бөгөөд манай улсаас соёлын ангилалаар бүртгэгдсэн анхны дурсгалт газар болсон. Энэхүү соёлын дурсгалт газар нь Улаанбаатар хотоос 360 км зайд Архангай аймгийн Хотонт, Хашаат сум, Өвөрхангай аймгийн Хархорин, Бат-Өлзий, Хужирт сумын нутгийн зарим хэсгийг хамран орших бөгөөд хамгаалалтын үндсэн талбайг 121967 га, орчны бүсийг 61044 га, нийт 183011 га газраар тогтоосон бөгөөд Засгийн газрын 2006 оны 123 тогтоолоор тус газрын тусгай хамгаалалтын бүсийн хилийн цэсийг тогтоож, Дэлхийн өвийн хороогоор баталгаажуулсан байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бүс нутгийн тэнцвэрт хөгжлийг хангах, Нийслэл Улаанбаатар хотын хэт төвлөрөл, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулах, түүхэн өв соёлыг хадгалан уламжлах, аялал жуулчлалыг дэлхийн түвшинд хүргэх зорилгоор уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгаль экологид ээлтэй ногоон, ухаалаг "Шинэ Хархорум хот"-ыг байгуулан хөгжүүлж, иргэдийг эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс "Орхоны хөндийд шинэ хот байгуулах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 3 заалттай байх бөгөөд нэг дэх заалтад Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд Шинэ Хархорум хотыг байгуулахаар тогтоож, хоёр дахь заалтад Орхоны хөндийд шинэ хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоон, холбогдох хууль тогтоомжийн дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, Шинэ

Хархорум хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгах, мөн тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох байнгын хороонд тус тус даалгахаар тусгана.

Гурав.Тогтоол батлагдсантай холбогдуулан үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар

Шинэ хот байгуулагдсанаар орон нутгаас Нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулж, хүн амын хэт төвлөрлөөс үүдэлтэй тулгамдаж буй асуудлуудыг тодорхой түвшинд шийдвэрлэхийн зэрэгцээ, нийгэм, эдийн засгийн ойрын болон ирээдүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх тогтвортой, байгаль орчинд ээлтэй бөгөөд нийгмийн сайн сайхны төлөө дэлхийн жишигт хүрсэн хот болж хөгжих бөгөөд дараах үндсэн асуудлуудыг шийдвэрлэнэ.Үүнд:

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050” болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжилтийг хангана.

Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, хот байгуулалтын тэнцвэрт хөгжлийг бий болгоно.

Үндэсний соёл, иргэншлийн өв уламжлалыг хадгалсан, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангасан ногоон, ухаалаг шинэ хотыг байгуулах замаар Орхоны хөндийг засаг захиргаа, түүх соёл, аялал жуулчлалын идэвх өндөр бүс болгож хөгжүүлнэ.

Улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, шинжлэх ухаан, технологи, инновацид тулгуурласан ажлын байрыг бүс, орон нутагт шинээр бий болгоно.

Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг дэлхий дахинд шинээр таниулж, соёл, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, тогтоолыг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар.

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---

ТАНИЛЦУУЛГА

“Орхоны хөндийд хот байгуулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа -2050” баримт бичгийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан зорилт 8.2.-ын I үе шатны 8.2.3-т “Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ” гэж, II үе шатны 8.2.3-т “Шинэ нийслэлд төрийн захиргааны болон зарим нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэх ажлуудыг эхлүүлсэн байна”, III үе шатны 8.2.2-т “Шинэ нийслэлийг ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын бүтээлч хот болгоно” гэж тусгасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хавсралт 3.7.5-д “Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна”, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 дүгээр хавсралт 3.6.6-д “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийх” зорилтуудыг тус тус дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаар 2015 онд “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”-ыг баталж, ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих буюу хот, суурин газруудыг нийт иргэдэд зориулж аюулгүй, даван туулах чадвар сайтай, тогтвортой болгох тухай 11 дүгээр зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэхүү агуулгад тусгагдсаны дагуу хотжилтыг тогтвортой хөгжлийн зорилтуудын харилцан уялдах боломж хэлбэрээр хангах, хөгжлийн багаж, хөдөлгөх хүч болгохын үүднээс 2016 онд “НҮБ-ХАБИТАТ III их хурал”-аас баталсан “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд гишүүн улс орнуудын Засгийн газрууд анхаарч хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Монголчууд бид уламжлалт нүүдэлчин ахуй, соёлтой ард түмэн учраас эх газрын эрс тэс уур амьсгалтай, уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагт хүн амыг нутагшуулж, суурин газрыг хөгжүүлж ирсэн түүх нь дэлхийн бусад орнуудаас өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг. Судлаачдын судалж илрүүлсэнээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Хүннү гүрний буюу МЭӨ III зууны үеэс ХХ зууны эхэн үе хүртэлх хугацаанд хамаарагдах 300 гаруй хот суурины дурсгалыг бүртгэн тэмдэглэсэн байна. XIII зууны Монголын Эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг байгуулсан үеэс тал нутагт суурин газрын соёл нэвтэрч эхэлсэн бөгөөд түүнээс хойш нийгмийн хөгжлийн үе шатуудад үндэсний уламжлал, баялаг, өв соёлдоо түшиглэн тухайн нөхцөл байдалтай уялдсан архитектур, хот байгуулалтыг хөгжүүлж ирсэн түүхтэй. ХХ зууны дунд үеэс Монгол Улсад аж үйлдвэрлэлийн шинэ салбаруудыг хөгжүүлсэнээр хүн ам суурин амьдрал, хотжилт руу хурдацтай шилжих үе эхэлж орчин үеийн хот, тосгоныг олноор байгуулсан.

Өнөөдрийн байдлаар Нийслэл Улаанбаатар хотод манай улсын хүн амын 50 орчим хувь нь төвлөрч, төрийн байгууллагууд 100 хувь, их, дээд сургуулиудын 90 хувь, худалдаа үйлчилгээний 86 хувь, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Нийслэлийн хүн амын энэхүү эрчимтэй өсөлтийг дагаад хүрээлэн буй орчны доройтол, дэд бүтцийн даац хэтрэх, бүс нутгийн тэнцвэрт бус хөгжил, хотын ажилгүйдэл, ядуурал ихсэн хүн амын хэт төвлөрөл нь хот болон хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдалд

хүргэж нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бий болгосоор байна. Мөн Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо нь нэг төвтэй болж, зарим талаар нийгмийн эрчимтэй хөгжилд сөрөг нөлөөг үзүүлэх үндсэн шалтгааны нэг болж байна. Тиймээс хүн амыг нутаг дэвсгэртээ тэнцвэртэй нутагшуулан суурьшуулах, Нийслэл Улаанбаатар хотоос бусад хот сууринг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Дэлхийн улс орнуудын хэмжээнд сүүлийн жилүүдэд иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг тэгшитгэх, хэт төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах зорилгоор хүн ам хэт төвлөрсөн томоохон нийслэл хотуудыг бүхэлд нь болон хэсэгчлэн нүүлгэх, төр, захиргааны байгууллагуудыг байршлыг шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, улсын нийслэл хотоо нүүлгэн шилжүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улс, Малайз Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бразил Улс зэрэг гадаад орнуудын туршлагаас үзэхэд хуучин нийслэл дэх хэт төвлөрөл тодорхой хэмжээнд буурсан, хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит үр нөлөөг үзүүлсэн жишээ байна.

Барилга, хот байгуулалтын яамнаас Орхоны хөндий орчимд хот байгуулалтын судалгааг үе шаттай хийж ирсэн бөгөөд 2005 онд шинэ хотын байршлыг урьдчилсан байдлаар тогтоох судалгаа, 2006 онд нийслэлийн баримжаатай жишиг хотын экологи-хот байгуулалтын үнэлгээ, 2009 онд Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, 2012 онд “Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын ирээдүйн төлөв, архитектур хот төлөвлөлт” судалгааны ажил /БШУЯ/, 2022 онд Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэлийг тус тус боловсруулсан.

Мөн Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /ЖАЙКА/-ын техник туслалцааны хүрээнд Барилга, хот байгуулалтын яам болон Үндэсний хөгжлийн газар /хуучнаар/-тай хамтран 2019-2021 онд хэрэгжүүлсэн “Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах төсөл”-ийн тайланд “Нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлтийг оновчтой болгох, шинэ нийслэл хотыг Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хот эсвэл улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт байрлуулах” саналыг дэвшүүлсэн байна.

Түүхэн ач холбогдолын хувьд Орхон голын сав нутаг, Орхоны хөндийн газар нь нүүдлийн соёл иргэншлийн газарзүйн гол зангилаа нутаг төдийгүй байгаль дэлхийтэй энгийн арга хэлбэрээр зохицон амьдарч байгааг харуулсан нүүдлийн ахуйг өдгөө ч хадгалсаар байгаа газар нутгийн төлөөлөл юм. Үүний зэрэгцээ хүн төрөлхтний нэн эртний түүхийг гэрчлэх чулуун зэвсэгийн үеийн дурсгал газрууд болон нүүдэлчдийн анхны төрт улс үүссэн, эртний нүүдэлчдийн төр улсууд үе залгамжлан оршин тогтнож өрнө, дорнын харилцааны түүхэн төв болж байсныг гэрчлэх археологи-архитектурын дурсгалуудыг өнөөг хүртэл хадгалж ирсэн газар нутаг. Мөн Их эзэн Чингис хааны үндэслэн байгуулсан Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хот, Монгол дахь бурханы шашины бэлэг тэмдэг болсон Эрдэнэзуу, Төвхөн, Шанхын хүрээ зэрэг олон хот суурин газруудыг байгуулж байсан түүхтэй өлгий нутаг юм. 2004 онд ЮНЕСКО-ийн дэлхийн соёлын өвд “Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг” бүртгэн авсан.

Дээр дурьдсан хэрэгцээ шаардлагад үндэслэн дэлхийн жишигт хүрсэн тогтвортой, ногоон, ухаалаг “Шинэ Хархорум хот”-ыг байгуулан хөгжүүлэх зорилгоор Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр заасны дагуу “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд Шинэ Хархорум хотыг байгуулахаар тогтоож, Орхоны хөндийд шинэ хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоон, холбогдох хууль тогтоомжийн дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, Шинэ Хархорум хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгах, мөн тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгахаар тусган боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот**Орхоны хөндийд хот байгуулах тухай**

Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, “Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2001 оны 09 дүгээр тогтоол, “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоол, “Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2003 оны 01 дүгээр тогтоол, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд Шинэ Хархорум хотыг байгуулсугай.

2.Шинэ Хархорум хотыг байгуулахтай холбогдуулан дараах арга хэмжээг 2023-2030 он хүртэлх хугацаанд үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Шинэ Хархорум хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах;

2/Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах;

3/Шинэ Хархорум хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Мөнхбат/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

**“ОРХОНЫ ХӨНДИЙД ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙГ УЛСЫН ИХ ХУРЛЫН НЭГДСЭН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС**

Д/Д	НЭР	АЛБАН ТУШААЛ
1	Б.МӨНХБААТАР	Барилга, хот байгуулалтын сайд
2	С.МАГНАЙСҮРЭН	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга
3	Ц.БАЯРБАТ	Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
4	О.ОДБАЯР	“Барилгын хөгжлийн төв” ТӨУУГ-ын Хот байгуулалт, зураг төслийн институтын эрхлэгч
5	Б. ОДБААТАР	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Хот байгуулалтын хэлтсийн дарга
6	Т.ГАНЗОРИГ	Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер